




Монгол улс Шатрын бодлого зохиомжийн олон улсын  
байгууллагад (WFCC) элссний (1988-08-28)


## 25 жилийн ойн нэрэмжит Бодолтын онлайн уралдаан

№1




# 2

№2




#3

№3




# 3

№4




# 6

№5



s # 2

№6



h# 2 (бүх шийдийг олох)

[s# -цагаан тал эхлэн хар талыг албадан нүүлгэж өөрийн ноёноо албадан мэдлуулахыг урвуу (self) мэд,  
h# -хар тал эхлэн нүүж цагаан талд туслан өөрийн ноёноо мэдлуулахыг хамжаа (help) мэд гэнэ]

Бодолтын ДАШТ болон олон улсын тэмцээний стандарт даалгаварт урвуу ба хамжаа мадын бодлогууд багтдаг, Монголын Бодогчдын чансааг (<http://www.mongolchess.mn/index.php/2012-09-02-02-47-53/bodlogo> буюу <http://www.mongolchess.com/problem/91-bbrat01> -д үзнэ үү) тооцдог болсон, олон улсын төвшинд өрсөлдөх Үндэсний бодогчдыг төрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх шаардлага зэргийг үндэслэн эдгээр төрлийг цаашид Бодолтын тэмцээн, уралдааны даалгаварт оруулж байхаар тогтов.

Уралдааныг дүгнэхэд даалгавруудын шийдийг зөв олсон эсэх, эхний нүүдлийн зорилго (занал буюу цугцванг) болон хамгаалалтын хувилбаруудыг, мэдлэх нүүдлийн хамт бүрэн заасан байдал, зохиогчийн санааг тодорхойлсон зэргийг гол үзүүлэлт болгон оноо өгөх бөгөөд оноо тэнцсэн тохиолдолд бодсон (хариу илгээсэн) хугацааг тооцно. Нийт 33 онооны 50-иас дээш хувийг авсан Бодогчдын чансаа нэмэгдэнэ.

Оролцогчид хариугаа **ЗӨВХӨН ГАНЦ УДААГИЙН !!** захиагаар 2013-9-11ний дотор [togookhuu\\_1@yahoo.com](mailto:togookhuu_1@yahoo.com) хаягаар өөрийн овог нэр, нас, цол зэрэг, байгууллага буюу нутаг дэвсгэрийн харъяаллын хамт ирүүлнэ үү. Уралдааны дүнг 2013 оны 9-р сарын 20ны дотор гаргаж [www.hosmaster-chess.mn](http://www.hosmaster-chess.mn) сайтад мэдээлэх бөгөөд эхний 3 байрт шалгарсан Бодогчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

**ШАТРЫН “Хос мастер” АКАДЕМИ  
2013-8-28**

Жич: Шатрын бодлого зохиомжийн төрлүүд, бусад мэдээлэл, бодлого бодох зөвлөгөө болон даалгавруудын оноог хэрхэн тооцож дүгнэдэг зэргийг манай [www.hosmaster-chess.mn](http://www.hosmaster-chess.mn) сайтын “Уран мэд” буланд үзнэ үү.

## **Товч танилцуулга**

### **Монгол улс WFCC-д элссний 25 жилийн ойд.**

ОУШХ-ны (FIDE) дэргэдэх Шатрын бодлого зохиомжийн олон улсын байгууллага (WFCC)-д Монгол улс 1988 оны 8-р сарын 28нд 22 дахь гишүүнээр нь элссэн билээ.

Монголын зохиогчид Дэлхийн багийн тэмцээнд 9 удаа оролцож хамжаа мадын төрөлд Дэлхийн хүндэт мастер, ОУХМ С.Чимэдцэрэн 2-р, гурван нүүдлийн төрөлд ОУХМ Л.Тогоохүү 5-р байрын болон бусад олон амжилт үзүүлж байв.

Бодлого, этюд зохиох Олон улсын тэмцээнүүдэд Монголын зохиогчид 80 шахам удаа шагналт байруудыг эзэлсэн бөгөөд тэдний 300 гаруй бүтээлүүд хүндэт болон магтаалт үнэлгээнд шалгарсан юм.

Монгол улс бодлого зохиох олон улсын 14 уралдааныг эх орондоо амжилттай зохион байгуулж тэдгээрт давхардсан тоогоор 27 орны 900 шахам зохиогчид 2000 гаруй бүтээлээ ирүүлэн оролцов.

Дотооддоо бодолтын шууд болон эчнээ тэмцээн, уралдаан 70 гаруй удаа зохион явуулж шатрын бодлого зохиомжоор 8 ном, товхимол хэвлүүлсний үр дүнд ОУХМ Г.Лхагвасүрэн (1949-2006), СМ Б.Буяннэмэх, СМ Ц.Сэр-Од (1926-2011), ДМ С.Дэнзэн (1929-1992), ДМ С.Самбуу (1925-1986), ДМ Х.Цагаанхүү, ДМ Г.Цогнийсүрэн нарын 10 гаруй зохиогчид төрөн гарсан юм.